МЭДЭЭ · 2020 оны 1-р сарын 24

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ ШАЛГАГДАЖ БАЙХ ХУГАЦААНДАА ЭХНЭРИЙНХЭЭ АМЬ НАСЫГ ХОХИРООСОН ХЭРГИЙГ ШҮҮХ ШИЙДВЭРЛЭЖЭЭ



2019 оны 9 дүгээр сарын 03-наас 04-нд шилжих шөнө Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт иргэн Б нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эхнэр Ө-г санаатай алсан гэмт хэрэг гарсан.

Сүхбаатар дүүргийн прокурорын газраас дээрх хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж, прокурорын яллах дүгнэлт үйлдэн тус дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн бөгөөд энэ оны 1 дүгээр сарын 14-ний өдөр шүүхээр хэргийг хянан хэлэлцэж, шүүгдэгч Б-г гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь хэсэгт зааснаар 17 жилийн хорих ялыг хаалттай дэглэмд эдлүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөрдөн шалгах ажиллагаагаар иргэн Б өмнө нь эхнэрээ 2 удаа зодож Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдэж байсан бөгөөд гэмт хэрэг үйлдэх үедээ мөн эхнэрээ зодсон асуудлаар Зөрчлийн хэрэгт шалгагдаж байсан болох нь тогтоогдсон байна.

Иймд тус дүүргийн прокурорын газраас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн хэргийн судалгаа гарган, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, дүүргийн Цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах хэлтсийн мөрдөгч нартай хамтарсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулжээ.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн бүх хороодод мэдэгдэл бичиж, үр дүнтэй нь танилцах ажлыг хийсэн байна.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2979